

ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ХҮМҮҮНЛЭГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ БАЙРНЫ ДОТООД ЖУРАМ

Нэг. ОЮУТНЫ БАЙРАНД БАРИМТЛАХ ДЭГ

- ХДС-ийн дотуур байр нь оюутан хүн хэвийн амьдрах нөхцөлөөр хангагдахуйц тоноглогдсон байна;
- Оюутны байранд оюутан байрлуулах асуудлыг салбар сургуулиас олгосон зөвшөөрлийн хуудсыг үндэслэн байрны зохицуулагч гүйцэтгэнэ;
- Оюутан хүлээн авахдаа эцэг, эх болон байрны зохицуулагч хоёрын хамтарсан гэрээ байгуулна;
- Оюутны байрны нийтийн эзэмшлийн хонгил, шат, халуун ус, 00оос бусад талбайг байранд суугч оюутан цэвэрлэнэ;
- Байрыг цэвэр үзэмжтэй шаардагдах тоног төхөөрөмжөөр хангаж хичээлийн жилийн эхэнд эзэмшигчдэд картаар хүлээлгэн өгч, гарсан тохиолдолд хүлээн авч байна;
- Байранд суугч оюутан бүр өрөө тасалгаагаа цэвэр нямбай эзэмшиж байрны үйлчилгээний газруудаар зөв боловсон үйлчлүүлж тогтоосон цагийн хуваарийг нарийн баримтлана;
- Байрнаас буюу оюутны зөвлөлөөс зохиогдож буй олон нийтийн ажилд тогтмол оролцож байна;
- Эцэг, эхийг зохицуулагчийн зөвшөөрөлтэйгөөр 3 хоног, төрсөн ах дүүг 1 хоног байрлуулна;
- Байрны дотоод журамтай танилцан түүнийг бүрэн биелүүлэхээ зөвшөөрсөн байна;

Хоёр. ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- Оюутны байрны цагийн хуваарийг зөрчих;
- Хуваарилж өгсөн өрөө тасалгаа, тавьсан эд хогшлыг дур мэдэн солих, өрөө тасалгааны болон нийтийн эзэмшлийн эд хогшил, тоноглол, цоожийг эвдэх, хэмхлэх;
- Байранд цэвэрч бус суух, гадны хүмүүсийг зөвшөөрөлгүй оруулах;
- Согтууруулах ундаа оруулах, хэрэглэх, байраар сэлгүүцэх, ноцолдох, хөгжим чанга дуугаар сонсох зэргээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах;
- Өрөөний хананд хадаас хадах, цонх салхивчийг онгойлгон эзгүй орхих, тагтаар хог хаях;
- Тагтаар хүн оруулах, гаргах, угаалтуур, суултуур дотор элдэв хог хаягдал хийхгүй байх; Хөлдөөгчинд хийх махны хэмжээг хэтрүүлэх;
- Охид, хөвгүүдийг нэг өрөөнд хамт оруулах;
- Муур, нохой болон бусад амьтан тэжээх; Оюутны байранд ямар нэгэн үйлчилгээ явуулах;
- Хүнсний мухлагт архи, тамхи, хугацаа хэтэрсэн бараа бүтээгдэхүүн зарахыг хориглох;

- Цахилгааны гэмтэлтэй болон, хэт өндөр цахилгаан хэрэглэдэг тогоо болон плитка ашиглахыг хориглоно;

Гурав. ЗӨРЧИЛ ГАРГАСАН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- Байранд суугчид нь зохицуулагчийн тавьсан шаардлагыг биелүүлнэ. Эс биелүүлбэл хариуцлагын талоныг цоолох ба гурван удаа цоолуулсан тохиолдолд оюутны байрыг суллаж өгнө;
- Цонх, тагтаар хүн оруулах, гаргах, байранд архи уух, танхайрах зэрэг ноцтой зөрчил гаргавал байрнаас албадан гаргаж төлбөрийг буцааж олгохгүй;